133

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 03 сарын 29 өдөр Дугаар 99 Улаанбаатар хот

## Хуулийн хэрэгжилтийг хангах тухай

"Хүнсний тухай хууль"-ийн 9.1.1, 9.1.2. дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Хүн амын хоол тэжээлийн үндэсний хэмжээний судалгааг таван жил тутамд хийж, үр дүнг холбогдох төрийн байгууллага болон нийтэд мэдээлж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хоол судлалын хэлтэсд даалгасугай.

2. Хүн амын зохистой хооллолт болон эрүүл хүнсний талаар зөвлөмжийг үндэслэн хүн амын бүлэг тус бүрийн өвөрмөц хэрэгцээ, шаардлагад нийцсэн мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

3. Дээрх арга хэмжээнд шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн болон улсын төсөвд суулгах замаар шийдвэрлэж байхыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нар, тус яамны Санхүү, эдийн засгийн хэлтэс/Дамдиндорж/-т тус тус даалгасугай.

4. Энэхүү журмын хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс(С.Эвлэгсүрэн)-т, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)- т тус тус үүрэг болгосугай.

САЙД Н.УДВАЛ

001678